



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2014 он 03 дугаар
сарын 28 ны өдөр

Дугаар ...*ХЭГ*/548

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ц.ГАНБОЛД ТАНАА


Тайлан ирүүлэх тухай

Засгийн газрын 2014 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаар Иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэд, төрийн бус байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар танилцаад 9 дүгээр тэмдэглэлээр Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан ажлын хүрээнд ямар ажил, арга хэмжээ зохион байгуулж байгаа талаарх танилцуулга бэлтгэж 2014 оны 1 дүгээр улирлын тайлантай хамт ирүүлнэ үү.

Мөн улирал, хагас жил, бүтэн жилийн тайлангийн тоон мэдээг 1, 2, 3 дугаар хавсралтын дагуу үнэн зөв, бодитой, тодорхой гаргаж хуулийн хугацаанд ирүүлэхэд анхаарна уу.

Тайланд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас шилжүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дэлгэрэнгүй тайланг гаргаж ирүүлж байхыг хүсье.

Дэд дарга



Ч.САЙНБИЛЭГ

..... оны улирал /хагас, бүтэн жил/-д иргэдээс төрийн захиргааны төв байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт %/
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
1							
2							
3							
	дүн						

1.Шийдвэрлэж хариу өгсөн гэдэгт нийт шийдвэрлэсэн өргөдөл гомдлын дүнг бичнэ.

2.Бусад байгууллагад шилжүүлсэн гэдэгт хүсэлт гаргасан асуудлаар хариуцах холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлснийг

3.Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн гэдэгт Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан хугацаа хэтэрч шийдвэрлэсэн байдлыг

4.Хугацаа болоогүй гэдэгт Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан хугацаа болоогүй, шийдвэрлэлтийн шатанд байгаа болон судлагдаж байгаа өргөдөл гомдлын тоог бичнэ.

5.Шийдвэрлэлт %/ гэдэгт нийт өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувийг бичнэ.

6.Дүн гэдэгт бүх байгууллагын нэгдсэн дүнг гаргаж бичнэ.

**2013 онд иргэдээс төрийн захиргааны төв байгууллагад
хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт
/хэлбэрээр/**

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	Үүнээс:					
			Бичгээр	11-11 төвөөр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
1.								
2.								
3.								
ДҮН								
Тайлбар:								

1. **Байгууллагын нэр** гэсний дор харьяа агентлаг, сум, дүүргийн үзүүлэлтийг гаргаж, **ДҮН**-д нэгтгэнэ.

2. **Нийт ирсэн өргөдөл гомдол, санал, хүсэлт** гэдэгт тухайн тайлангийн хугацаанд ирсэн бүх өргөдөл, гомдол, санал, хүсэлт /бичгээр, цахимаар, утсаар ... гм / -ийг нэгтгэж бичнэ.

3. **Бичгээр** гэдэгт зөвхөн бичгээр ирсэн өргөдөл гомдлын тоог, **11-11 төвөөр** гэдэгт Засгийн газрын 11-11 төвөөс системээр шилжүүлсэн, **цахим хэлбэрээр** гэдэгт /mail, message, twitter, facebook гэх мэт/ цахим системээр ирсэн, **утсаар** гэдэгт иргэдийг сонсох тусгай дугаарт утас болон албан тушаалтантай утсаар ярьж санал, хүсэлтээ илэрхийлсэн байдлыг, **биечлэн уулзсан** гэдэгт холбогдох албан тушаалтантай иргэн биечлэн уулзаж, санал хүсэлтээ илэрхийлсэн, **бусад** гэдэгт хүнээр дамжуулсан, уламжилсан, уулзалт, өдөрлөг болон зохион байгуулалттай арга хэмжээний үеэр болон бусад байдлаар санал, хүсэлтээ илэрхийлсэн байдлыг нэгтгэж тус тус бичнэ.

4. **Тайлбар** гэдэгт тухайн байгууллагын удирдлагатай уулзах хүсэлт гаргасан нийт хэдэн иргэнээс хэдийг ямар албан тушаалтан хүлээн авч уулзсан, асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар болон бусад тайлбартай асуудлыг бичнэ.

Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн агуулга /%-аар/

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал /тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/

Тайлбар: энэ хүснэгтэд нийт ирсэн өргөдөл гомдолд хүсэлт санал ... хувь, гомдол ... хувь, хамгийн өндөр хувийг эзэлж байгаа асуудлаас эхлэн эзлэх хувь тавьж жагсааж бичнэ.